

ЗХАНЗХ-ны Байгаль орчны хорооны 14-р хурлын тайлан

2019 оны 11 сарын 14-ний өдөр Тояама мужид ЗХАНЗХ-ны Байгаль орчны хорооны 14-р хурал болж өнгөрсөн.

Энэ удаагийн хурлаар Байгаль орчны хорооны хурлын зохицуулагчаар Тояама муж үргэлжлүүлэн ажиллахаар сонгогдсон. Хурлаар 2016 оны Тояамагийн тунхагийн дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, саналууд тавигдсан. Байгаль орчны хорооны 2020 онд 6 төсөл(Тояама мужаас 3, БНСУ-ын Чүнчоннам мужаас 2, ОХУ-ын Томск мужаас 1) хэрэгжүүлэх санал гарсныг хуралд оролцогч орон нутгууд зөвшөөрснөөр төслийг хэрэгжүүлэхээр болсон.

1 Зорилго

ЗХАНЗХ-ны гишүүн орон нутгуудаас явуулж буй байгаль орчныг хамгаалах чиглэлийн төслийг саадгүй хэрэгжүүлэх, мэдээлэл солилцох, бүсийн байгаль орчныг хамгаалахыг зорино.

2 Болсон хугацаа • газар

- 2019 оны 11 сарын 14-ний өдрийн 9 цаг 30 минутаас 16 цаг хүртэл
- Оакс Канал Парк зочид буудал Тояама (Тояама мужийн Тояама хотын Үшижимамачи 11 -1 тоот)

3 Зохион байгуулагч

Тояама муж, ЗХАНЗХ(NEAR)

(NPEC сан нь Тояама мужийн захиалгаар ЗХАНЗХ-ны Байгаль орчны хорооны үйл ажиллагааг хариуцан ажилуулж байна)

4 Оролцсон орон нутаг

3 улс, 7 орон нутаг

- БНХАУ (1) : Хэйлонжан муж • Япон улс (2) : Ямагата муж, Тояама муж
- ОХУ (2) : Приморын хязгаар,Хабаровск хязгаар (ажиглагч)
- БНХАУ (1) : Ляонин муж • Япон улс (1) : Сага муж

5 Гол үр дүн

(1) Хорооны дараагийн зохицуулагч орон нутгийг сонгосон.

Байгаль орчны хорооны дараагийн зохицуулагчаар Тояама муж сонгогдсон (Ажиллах хугацаа : 2 жил)

(2) 2019 оны төслийн хэрэгжилтийн тайлан

2019 оны төслийн хэрэгжилтийн байдлын талаар орон нутгууд тайлан тавьсан.

| 2019 оны төслийн нэр | Санал гаргасан орон нутаг |
|---|--|
| Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудыг байгаль орчны манлайлагч болгон хөгжүүлэх хөтөлбөр | ОХУ-ын Хабаровск хязгаар Тояама муж |
| Далайн хог хаягдлын гаралтыг багасгах тухай судалгаа, хөгжүүлэлтийн хөтөлбөр | Тояама муж |
| Зүүн хойд Азийн байгаль орчны зурагт хуудасны үзэсгэлэн | Тояама муж |

| | |
|---|-----------------------|
| Далайн амьд биетийн судалгаа | Тояама муж |
| Хүүхэд залуучуудад зориулсан хясаа ашигласан цэнхэр карбон байгаль орчны сургалт, танин мэдэхүйн хөтөлбөр | БНСУ-ын Чүнчоннам муж |
| 「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйлс сельфи зургаар」 гэрэл зургийн уралдаан | ОХУ-ын Томск муж |

(3) 2020 онд хэрэгжүүлэх төслийн санал, Байгаль орчны үйл ажиллагааны төлөвлөгөө

2020 онд 6 төслийг хэрэгжүүлэх санал гарсан бөгөөд гишүүн орон нутгууд уг саналыг зөвшөөрсний дагуу хэрэгжүүлэхээр болсон.

Мөн тусгай төслийн хүрээнд байгаль орчны асуудлын талаарх дэлхийн чиг хандлагад үндэслэн SDGs хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах, далайн хуванцар хог хаягдалтай тэмцэхийн төлөө хичээхийн зэрэгцээ 「2016 оны Тояамагийн тунхаг*」 -ын дагуу Зүүн хойд Азийн бүсийн байгаль орчныг хамгаалах чиглэлийн тодорхой үйл ажиллагааны нэг болохын хувьд ч төслийг хэрэгжүүлэхэд анхаарах болсон.

| 2020 онд хэрэгжүүлэх төслийн санал | Төслийг санаалчилсан орон нутаг |
|---|---------------------------------|
| Зүүн хойд Азийн хүүхэд залуучуудад зориулсан байгаль орчны манлайлагч бэлтгэх хөтөлбөр | Тояама муж |
| Далайн хог хаягдлын гаралтыг багасгах тухай судалгаа, хөгжүүлэлтийн хөтөлбөр | Тояама муж |
| Зүүн хойд Азийн байгаль орчны зурагт хуудасны үзэсгэлэн | Чүнчоннам муж |
| Далайн амьд биетийн судалгаа | Тояама муж |
| Хүүхэд залуучуудад зориулсан хясаа ашигласан цэнхэр карбон байгаль орчны сургалт, танин мэдэхүйн хөтөлбөр | Чүнчоннам муж |
| 「Eco-selfie – Байгаль орчныг хамгаалах үйлс сельфи зургаар」 гэрэл зургийн уралдаан | Томск муж |

(4) Орон нутгууд байгаль орчны тэргүүний бодлогын талаар мэдээлэл солилцсон.

БНХАУ-ын Ляонин муж ба Оросын орон нутгаас байгаль орчны тэргүүний бодлогын талаар ирлтэгл тавьсан бөгөөд дараагаар нь идэвхтэй мэдээлэл солилцсон.

| Илтгэлийн нэр | Илтгэгч орон нутаг |
|---|--------------------------|
| Ляонин мужийн агаарын бохирдлыг бууруулах • хянах үйл ажиллагаа | БНХАУ-ын Ляонин муж |
| Приморийн хязгаарын байгаль орчныг хамгаалах бодлогын талаар | ОХУ-ын Приморийн хязгаар |

(5) Бусад

- 2019 оны 10 сард Тояама мужид болсон 「Дэлхийн хамгийн үзэсгэлэнт далайн булантай орнуудын клуб」 -ын дэлхийн чуулганаар Байгаль орчны хорооны төслөөс авахуулаад тус мужийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа өндөр үнэлгээ авч энэ нь 「Далайн булангийн тухай Тояамагийн тунхаг」 -т багтсан талаар Тояама мужаас танилцуулсан.
- Дараах өдөр нь буюу 15-ны өдөр хуралд оролцогчид Тояама хотын эко хотхонтой танилцсан.

【Хурлын үеэр】



* Зүүн хойд Азийн орон нутгуудын байгаль орчны мэргэжилтнүүдийн хурлаас Тояамагийн тунхаг (Тояамагийн тунхаг 2016) -ын тухайд 2016 оны 5 сард G 7 Тояамагийн байгаль орчны яамдын сайд нарын хурал болсонтой уялдуулан Тояама мужаас Хятад-Солонгос-Япон-Оросын орон нутгийн захиргааны байгууллагуудын ажилтнуудыг оролцуулсан 「Зүүн хойд Азийн орон нутгуудын байгаль орчны мэргэжилтнүүдийн хурал 2016 in Тояама」 арга хэмжээг зохион байгуулж, Зүүн хойд Азийн бүсийн баялаг байгаль орчныг хойч үедээ өвлүүлэхийн тулд байгаль орчныг тэр чигээр нь хадгалах үйл ажиллагааг явуулах 「Тояамагийн тунхаг 2016」 -г баталсан.

Тунхагт 「Дэлхийн байгаль орчныг хамгаалах үйлсэд идэвхтэй хувь нэмэр оруулах」, 「Иргэдийн хамтын үйл ажиллагаа, байгаль орчны сургалтыг явуулах」, 「Олон улсын түвшинд яриа хэлэлцээ хийх」 тодорхой үйл ажиллагааны чиглэл багтсан байдаг.